



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 03 сарын 01 өдөр

Дугаар А/С9

Мандалговь

"ЦОДГОР ХҮҮ-2022" Өсвөрийн шатарчдын
аймгийн аварга шалгаруулах тэмцээнд оролцогчдод
сургалт зохион байгуулах тухай

Хүүхдийн эрхийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3, 15 дугаар зүйлийн 15.1.4, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, сангийн сайдын 2022 оны 01 дүгээр сарын 31-ны өдрийн "Аргачлал, зардлын норматив батлах тухай" А/23,27 тоот хамтарсан тушаалын 3 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хүүхэд багачуудын дунд шатрын спортыг сурталчлан дэлгэрүүлэх, авьяас билгийг нээн хөгжүүлэх, тэдний хөгжил, оролцоог нэмэгдүүлэх зорилгоор "Цодгор хүү-2022" аймгийн аварга шалгаруулах тэмцээний оролцогчдод 2022 оны 03 дугаар сарын 19-ний өдөр Шатрын онолын сургалтыг зохион байгуулсугай.

2. Сургалтын хөтөлбөрийг 1 дүгээр, төсвийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Үйл ажиллагаанд шаардагдах 600,000 (Зургаан зуун мянга) төгрөгийн зардлыг Нийгмийн бүлэгт чиглэсэн хөтөлбөрөөс санхүүжүүлэхийг нягтлан бодогч (С.Чинбат)-д зөвшөөрсүгэй.

4. Тушаалын хэрэгжилтийг хангаж, үр дүнтэй зохион байгуулж ажиллахыг Хүүхдийн оролцоо, хөгжил хариуцсан мэргэжилтэн (Л.Мөнхсарнай)-д үүрэг болгосугай.

5. Үйл ажиллагааны хэрэгжилтэнд хяналт тавьж үр дүнг 2022 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн дотор даргын дэргэдэх зөвлөлд танилцуулахыг мэргэжилтэн (Л.Мөнхсарнай)-д даалгасугай.

ДАРГА



Ц.ГАНЗОРИГ

№ 482201017

Дундговь аймгийн Гэр бүл, хүүхэд,
Залуучуудын хөгжлийн газрын даргын
2022 оны 03 дүгээр сарын 01 ний өдрийн
АКП дугаар тушаалын 01 дугаар хавсралт

"ЦОДГОР ХҮҮ-2022" ТЭМЦЭЭНД ОРОЛЦОХ ОРОЛЦОГЧДЫН
СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР

| № | Сургалтын сэдэв | Сургалтын цаг | Сургагч багш |
|------------------------------|-----------------------------------|---------------|-----------------------------------------------------------------------|
| 1. "Тоглоомын дүрэм" | | | |
| 1 | Боломжгүй нүүдэл гэж юу вэ | 10:00-10:10 | "Уран өрөг" шатрын холбооны ерөнхий нарийн бичгийн дарга М.Билгүүн |
| 2 | Анхааруулга гэж юу вэ | 10:10-10:20 | |
| 3 | Цайны завсарлага | 10:20-10:30 | |
| 4 | Ямар тохиолдолд сануулга өгөх вэ? | 10:30-10:40 | |
| 2. Бүх дүрсний нүүдэл | | | |
| 5 | Дүрмийн бус нүүдлүүд гэж юу вэ? | 10:40-10:50 | "Уран өрөг" шатрын холбооны ерөнхий нарийн бичгийн дарга М.Билгүүн |
| 6 | Гараа дунд үе, төгсгөл гэж юу вэ? | 10:50-11:00 | |

Дундговь аймгийн Гэр бүл, хүүхэд,
Залуучуудын хөгжлийн газрын даргын
2022 оны 03 дүгээр сарын 01 ний өдрийн
123 дугаар тушаалын 02 дугаар хавсралт

"ЦОДГОР ХҮҮ-2022" ТЭМЦЭЭНД ОРОЛЦОХ ОРОЛЦОГЧДОД ЗОХИОН
БАЙГУУЛАХ СУРГАЛТЫН ТӨСӨВ

| № | Зардлын зүйл | Оролцогчдын тоо | Хэмжих нэгж | Өртөг | Нийт /төгрөг/ | |
|----------|------------------------------------------------------------|-----------------|-------------|-------|---------------|---------|
| 1 | Сургагч багшийн хөлс | 80/1 | Хүн/цаг | 2,000 | 160,000 | |
| 2 | Сургалтын хэрэглэгдэхүүн (Шатар сонирхогчдын гарын авлага) | 80 | тоо | 2,500 | 200,000 | |
| 3 | Цайны зардал | Печень | 80 | тоо | 1,500 | 120,000 |
| | | ундаа | 80 | тоо | 1,500 | 120,000 |
| Нийт дүн | | | | | 600,000 | |

--000--